

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧДЫН 2006 ОНД БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВСАН БАЙДАЛ



ТЕНДЕРИЙН ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА

Улаанбаатар хот
2007 оны 12 дугаар сар

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн:

ҮАГ-ын Нэгдүгээр газар

Газрын захирал: Д.Ганбилэг

Аудитын менежер: Ж.Батсайхан

Ахлах аудитор: Ц.Гэрэл

Аудитор: С.Андруш

Д.Гандолгор

Шинжээч: Ш.Энхтайван

Б.Даваабаатар

П.Цэнгүүн

2007 оны 12 дугаар сар

Уг тайланг ҮАГ-ын Веб сайт-аас үзнэ
үү.
www.mnao.pmis.gov.mn

ХАЯГ:

Үндэсний аудитын газар
210642 Чингэлтэй дүүрэг,
Засгийн газрын 4 дүгээр байр,
Бага тойруу-6, Улаанбаатар-46
Монгол Улс

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй,
стандартын талаархи мэдэгдэл 2

Товчилсон үгсийн тайлбар..... 3

Бүлэг 1 Худалдан авах ажиллагааны
төлөвлөлтийг хууль тогтоомжид заасан⁴
шаардлагын дагуу хийгээгүй байна.

Бүлэг 2 Төсвийн ерөнхийлөн захирагчид
худалдан авах ажиллагааг хуулийн дагуу⁹
хэрэгжүүлээгүй байна.

Бүлэг 3 Гэрээний хэрэгжилтэд тавих
хяналт сул байна 17

Дүгнэлт 20

Зөвлөмж 21

Холбогдох байгууллагын санал 22

ҮАГ-ын тайлбар 25

Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой
асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах,
зүйл байвал 261885 дугаарын утас,
323266 дугаарын факсаар харилцана уу

Хавсралтууд:

Хавсралт-1

Хавсралт-2

Хавсралт-3.....

Монгол Улсын Ерөнхий аудиторовын тушаал

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаархи мэдэгдэл

Аудитыг УИХ-ын Төсвийн Байнгын хорооны санал, Монгол Улсын Ерөнхий аудиторт Үндэсний аудитын газраас 2007 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийв.

Төрийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагаатай холбоотой дараахь асуудлыг шалгаж, дүгнэлт гарган, зөрчил дутагдал илэрвэл түүнийг арилгах, үр ашгийг дээшлүүлэх санал зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ. Үүнд:

- Тухайн жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөлт
- Худалдан авах ажиллагааны зохион байгуулалт
- Худалдан авах ажиллагааны үр дүн

Аудитыг хийхдээ Төрийн хяналт шалгалтын стандарт, түүнийг хэрэгжүүлэх аргачилсан зөвлөмж, Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам, Гүйцэтгэлийн аудитын гарын авлага, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийг мөрдлөг болгон аудитын горимын дагуу нотлох зүйлс цуглуулж, дүгнэлт зөвлөмж боловсруулав.

Аудитын явцад асуудлыг шинжлэх, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, тайлбар тодруулга гаргуулах, холбогдох мэдээ, тайланг судлах, үнэлэх, харьцуулах зэрэг гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглалаа.

Аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу төсвийн ерөнхийлөн захирагчдаас харъяа агентлаг, байгууллагын худалдан авах ажиллагааны талаархи мэдээллийг урьдчилан бэлтгэсэн маягаар гаргаж ирүүлэхийг хүсснээр 22 төсвийн ерөнхийлөн захирагч, тэдгээрийн харъяа 28 байгууллага холбогдох мэдээллийг гаргаж ирүүлсэн байна.

Аудитын явцад 9 яам, тэдгээрийн харъяа 9 байгууллагын тендерийн холбогдолтой баримт материалд аудит хийж 2006 онд худалдан авах ажиллагааг зохих шаардлагын дагуу зохион байгуулсан эсэхэд үнэлэлт өглөө.

Захиалагчид худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримталсан эсэхийг аудитын шалгуур үзүүлэлт болгон авч үзлээ.

Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн шалгалтын журамд заасны дагуу аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ТАЙЛБАР

УИХ	Улсын Их Хурал
СЯ	Сангийн яам
ТЭХЯ	Түлш, эрчим хүчний яам
ХХААЯ	Хүнс, хөдөө аж ахуйн яам
БСШУЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар
БХБЯ	Барилга, хот байгуулалтын яам
ЗТАЖЯ	Зам, тээвэр, аялал жуулчлалын яам
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
БХЯ	Батлан хамгаалах яам
НХХЯ	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам
ҮХЯ	Үйлдвэр, худалдааны яам
БХБНААҮТ	Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн үндэсний төв
ХААБЗГ	Худалдан авах ажиллагааны бодлого, зохицуулалтын газар
ЭХСХТ	Эрчим хүчний судалгаа, хөгжлийн төв
СЭХҮТ	Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв
ШЦХГ	Шуудан, цахилгаан холбооны газар
ШБӨХЗГ	Шударга бус өрсөлдөөнийг хянан зохицуулах газар
ТӨХ	Төрийн өмчийн хороо
СЗХ	Санхүүгийн зохицуулах хороо

Бүлэг 1

Худалдан авах ажиллагааны төлөвлөлтийг хууль тогтоомжид заасан шаардлагын дагуу хийгээгүй байна

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48.1-д “Захиалагч худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг тухайн жилийн батлагдсан төсөвт багтаан боловсруулж улсын төсөв батлагдсанаас хойш 30 хоногийн дотор харъяалах төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлнэ”, 48.2-т “Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн төсвийн хүрээнд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг эцэслэн боловсруулж улсын төсөв батлагдсанаас хойш 45 хоногийн дотор төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ”, 48.5-д “Захиалагч худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тухайн жилийн эхний сард хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ” гэж тус тус заажээ.

2000 онд батлагдсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгох журмын тухай хуульд худалдан авах ажиллагааг төлөвлөх, хүргүүлэх, нэгтгэх, тайлагнах хугацааны талаар заалт байгаагүй.

Харин 2006 оны 2 дугаар сарын 1-нээс шинээр мөрдөгдөж байгаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд худалдан авах ажиллагааг төлөвлөх хугацааг хуульчилсан.

Худалдан авах ажиллагааны 2006 оны төлөвлөлтийг шинэчлэгдсэн хууль, тогтоомжтой харьцуулан үнэлэх боломжгүй тул Засгийн газрын 2000 оны 101 дүгээр тогтоолоор батлагдсан “Бараа, ажлын гүйцэтгэгчийг сонгоход баримтлах тусгай журам”-ыг гол шалгуур болгов.

Дээрх журамд заасны дагуу захиалагч тухайн жилийн худалдан авах ажиллагааг хэрэгжүүлэх график, төлөвлөгөөнд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний нэр, төрөл тус бүрээр тендерийн хороо байгуулах, тендерийн бичиг баримт бэлтгэж, батлуулах, тендерийн урилгыг зарлан мэдээлэх, тендерийг нээх, үнэлэх, гэрээ байгуулах, санхүүжүүлэх, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, гэрээ дүгнэх зэрэг ажлыг хэзээ, хэн, яаж хэрэгжүүлэхийг тодорхойлох ёстой.

22 төсвийн ерөнхийлөн захирагч, тэдгээрийн харъяа 28 агентлаг, байгууллага, нийт 50 захиалагчдын дунд явуулсан судалгааны дүнгээс харахад 90.0 хувь нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг харъяа дээд газартаа хүргүүлсэн, 18.5 хувь нь тухайн жилд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний жагсаалтыг нийтэд зарлан мэдээлсэн байна.

Дээрх төсвийн ерөнхийлөн захирагчдын 31.5 хувь нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг Сангийн яаманд хүргүүлсэн байна. Харин 82.8 хувь нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг зохих ёсоор баталгаажуулжээ.

Энэ нь өмнөх аудитаар хийгдсэн судалгааны дүнтэй харьцуулахад ахицтай боловч цаашид худалдан авах ажиллагааны төлөвлөлтийн явцыг улам боловсронгуй болгох, сахилга хариуцлагыг бүх шатанд дээшлүүлэх шаардлагатайг харуулж байна.

Худалдан авах ажиллагааны төлөвлөлт хугацаа алдаж байгаа нь түүний үнэ цэн, ач холбогдлыг бууруулж байна

Сангийн яамны ХААБЗГ-аас 2006 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 5 дугаар сарын 1-ний дотор баталж, олон нийтэд мэдээлэх, худалдан авах ажиллагааг шуурхай зохион байгуулахыг төсвийн ерөнхийлөн захирагчдад үүрэг болгожээ.

Үүний дагуу 2006 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 11 байгууллага 2 дугаар сарын 15-наас 5 дугаар сарын 18-ыг хүртэлх хугацаанд Сангийн яаманд ирүүлсний дотор ТЭХЯ 2006 оны 3 дугаар сарын 13-нд, БСШУЯ 2006 оны 3 дугаар сарын 17-нд, ОБЕГ 2006 оны 3 дугаар сарын 27-нд, ХХААЯ 2006 оны 5 дугаар сарын 18-ны өдөр тус тус ирүүлжээ. ЗТАЖЯ, БХБЯ төлөвлөгөө зохиосон боловч Сангийн яаманд ирүүлээгүй байна.

Зарим захиалагч худалдан авах ажиллагааг төлөвлөгөөнд заасан хугацааны дагуу гүйцэтгээгүй, төлөвлөсөн зарим арга хэмжээ хэрэгжих боломжгүй болсон нь төлөвлөгөөний ач холбогдлыг бууруулж байна. Тухайлбал:

- ТЭХЯ-ны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан Өндөрхаан-Баруун-Уртын 110 кВт-ын 214.5 км урт цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийг сонгох ажлыг 2006 оны 3 дугаар сарын 15-наас эхэлж, 6 дугаар сарын 1-ний дотор гэрээ хийхээр төлөвлөсөн боловч 4 дүгээр сарын 10-нд үнэлгээний хороо байгуулж, 2006 оны 12 дугаар сарын 26-ны өдөр гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан байна.
- БСШУЯ-ны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан Булган аймгийн Хутаг -Өндөр сумын 100 ортой дотуур байрны барилгын ажлын гэрээ байгуулах ажил хугацаанаас хоёр сараар хоцорч хэрэгжсэн байна.
- Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв сумдад салхин цахилгаан станц барих гүйцэтгэгчтэй байгуулах гэрээг хүйтэрсэн үед 2006 оны 11 дүгээр сарын 8-13-ны хооронд хийснээс ажил зогсож, батлагдсан санхүүжилтийн ихэнх олгогдоогүй, төсвийн зохицуулалт нэрийн дор өөр төслүүдэд зарцуулагджээ.
- Нийслэлийн Багануур дүүрэгт баригдах 170.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 25 машин, механизмын дулаан зогсоолын барилгын зураг, төсөл боловсруулах, барилгын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн үнэлгээний хороог 2006 оны 2 дугаар сарын 24-нд байгуулсан боловч зураг, төслийн тендер хоёр дахиж, 9 дүгээр сарын 20-нд гэрээ хийжээ. Зураг төсөл бэлэн болсны дараа барилгын ажлын нээлттэй тендер шалгаруулалт 12 дугаар сарын 5-нд зарласан ч гүйцэтгэгч сонгож чадаагүй тул хязгаарлагдмал тендер шалгаруулалт дахин зарлаж, он дамжин 2007 оны 2 дугаар сард гүйцэтгэгчтэй гэрээ байгуулжээ.

- УБ-Дарханы чиглэлийн замаас Төв аймгийн Жаргалант сум хүртэлх 60.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 20 км зам засварын ажлын үнэлгээний хороог 2006 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр байгуулж, нээлттэй тендер шалгаруулалт зарласан боловч шаардлага хангасан тендер ирээгүйн улмаас зам засварлах, хучилт хийхэд агаарын хэм +15-аас доошгүй байх засварын ажлын техникийн шаардлагыг зөрчихгүй байх, цаг хугацаа алдахгүй гэсэн үндэслэлээр харьцуулалтын аргыг сонгож, “Төв АЗЗА” ХК-тай 2006 оны 9 дүгээр сарын 25-ны өдөр гэрээ байгуулжээ.

Худалдан авах ажиллагааг төлөвлөх, зарлан мэдээлэхэд хугацаа алдаж байгаа нь захиалагчийн хариуцлагагүй байдлаас гадна Засгийн газар хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтыг оройтуулж баталсан, зураг төслийн тендер шалгаруулж, зураг, төсөл нь бэлэн болохыг хүлээх, бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт хийснээс үнэлгээний хороо байгуулагдахгүй удсан зэрэгтэй холбоотой байна. Тухайлбал;

Засгийн газрын 2006 оны 19 дүгээр тогтоолоор Улсын төсвийн хөрөнгөөр 2006 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтыг 2006 оны 2 дугаар сарын 13-ны өдөр баталж, 2006 оны 6 дугаар сарын 7-ны өдөр Засгийн газрын 127 дугаар тогтоолоор Улсын төсвийн хөрөнгөөр 2006 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга, байгууламжийн жагсаалтад нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

2006 онд Засгийн газар солигдсонтой холбоотой зарим яам бүтцийн өөрчлөлт хийсэн нь худалдан авах ажиллагаа хугацаа алдахад зарим талаар нөлөөлжээ. Тухайлбал, Засгийн газраас ТЭХЯ-ны стратеги, зохион байгуулалтын өөрчлөлтийн хөтөлбөрийг зөвшөөрч, зохион байгуулалтын бүтцийг баталсантай холбогдуулан 2006 оны 3 дугаар сарын 17-нд бүтцийн өөрчлөлт хийж зарим ажиллагсдыг томилж, чөлөөлсөн байна.

Үүнтэй холбоотой зарим үнэлгээний хороодыг байгуулах ажил хойшилсон байна. Тухайлбал, Дарханы Дулааны цахилгаан станцаас Дархан хот хүртэлх дулааны магистраль шугамын шинэчлэлийн ажлын зураг төсөл боловсруулах тендерийн үнэлгээний хороо төлөвлөснөөс 20 хоног хугацаа хоцорч 4 дүгээр сарын 10-нд байгуулагдсан, үүнээс шалтгаалж барилга угсралтын ажил ондоо эхлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46.1.8-д “барилга, зам, инженерийн шугам сүлжээ зэрэг тодорхой улиралд гүйцэтгэх онцлог шинж чанартай бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг тухайн жилийн 1 сарын 15-ны дотор эхлүүлэх”, 48.5-д “худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тухайн жилийн эхний сард багтаан хэвлэл мэдээллээр нийтэд зарлан мэдээлнэ” гэж заасныг зөрчиж байна.

Худалдан авах ажиллагаа төлөвлөсөн ёсоор хэрэгжихгүй байгаа өөр нэг шалтгаан нь төсвийн төсөлд тусгасан мэргэжлийн байгууллагын техник, эдийн засгийн үндэслэл бүхий хүчин чадал, тоо хэмжээг төсөв батлагдах шатанд үндэслэлгүй өөрчилдөгтэй холбоотой байна.

Өмнөговь аймгийн Сэврэй сумын төвийг салхины эрчим хүч ашиглан цахилгаанжуулах техник, эдийн засгийн үндэслэлийг 2005 онд Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв боловсруулжээ. Энэ нь салхин цахилгаан станц, салхи-дизель хосолсон станц, нарны цахилгаан станц гэсэн гурван хувилбартай бөгөөд үүнээс 60 кВт-ын хүчин чадалтай, 300.0 ам.мянган долларын хөрөнгө оруулалт шаардагдах салхин цахилгаан станц барих хувилбарыг сонгож 2006 оны төсвийн төсөлд тусгажээ.

Гэтэл төсөв батлагдах явцад дээрх төслийн техник, эдийн засгийн үндэслэлд заасан хүчин чадлыг 60 кВт байсныг 150 кВт болгон нэмсэн боловч урьдчилан тооцоолсон хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэлгүй хэвээр үлдээж баталснаас төсөв нь хүрэлцэхгүй болж хүчин чадлыг нь дахин багасгах тохиолдол гарчээ.

Өвөрхангай аймгийн Богд суманд 90 кВт-ын хүчин чадалтай, 557.5 сая төгрөгийн төсөвтэй салхин цахилгаан станц, Дорноговь аймгийн Мандах суманд 60 кВт-ын хүчин чадалтай, 484.0 сая төгрөгийн төсөвтэй салхин цахилгаан станц, Ховд аймгийн Цэцэг суманд 60 кВт-ын хүчин чадалтай, 807.2 сая төгрөгийн төсөвтэй нарны цахилгаан станц барихаар төлөвлөсөн боловч Засгийн газрын 2006 оны 19 дүгээр тогтоолоор дээрх сумдын салхин цахилгаан станцын хүчин чадлыг нь 150 кВт болгон нэмсэн боловч, төсвийг түүнтэй уялдуулж нэмэлгүй хуучнаар баталсны дотор Цэцэг сумын нарны цахилгаан станцыг мөн адил 150 кВт-ын хүчин чадалтай салхин цахилгаан станц болгон өөрчилж, төсвийг багасган 395.0 сая төгрөгөөр баталсан байна.

Гэтэл Цэцэг сумын төв хонхор газар байрладаг, салхины хүч бага учир Сангийн сайд, Түлш эрчим хүчний сайдын 2006 оны 199/58 дугаар тушаалаар 60 кВт-ын хүчин чадалтай нарны цахилгаан станц барихаар шийдвэрлэжээ.

2006 онд дээрх сумдын нарны болон салхин цахилгаан станцын гүйцэтгэгчийг сонгох нээлттэй тендер шалгаруулалт зарлахад шаардлага хангасан нэг ч санал ирээгүй байна. Захиалагчийн төсөвт өртгөөс компаниудын үнийн санал 1.5-3 дахин их байсан тул бүх тендерээс татгалзаж, батлагдсан төсөвт тохируулан хүчин чадлыг нь бууруулж хязгаарлагдмал тендер шалгаруулалт зохион байгуулжээ.

Үүний улмаас 2006 оны 11 дүгээр сард гэрээ хийгдсэн бөгөөд цаг агаар хүйтэрч, барилгын ажил зогсож, санхүүжилтийн ихэнх нь гүйцэтгэгчид олгогдоогүй байна. Эдгээр ажил 2007 онд хийгдэхээр хойшилжээ.

Цэцэг суманд баригдах нарны цахилгаан станцыг 395.0 сая төгрөгөөр “Ньюпрогресс” ХХК-тай гэрээ хийж барьж эхэлсэн ч 30 кВт-ын хүчин чадал нь сумын төвийн хэрэгцээг хангахгүйн улмаас УИХ-ын гишүүний хүсэлтийн дагуу Сангийн сайдаас Түлш, эрчим хүчний сайдад ирүүлсэн 2006 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 3-5г/4594 дүгээр албан бичгээр цаашид 100 кВт-ын нарны цахилгаан станц барих асуудлыг сайдын багцын хүрээнд авч үзэхийг хүссэн байна.

Улмаар 2007 онд “Ньюпаур” ХХК-тай гэрээ хийж, нэмэлт 780.0 сая төгрөгийн төсөвтэй 70 кВт-ын нарны цахилгаан үүсгүүрийг суурилуулж төсвийн хөрөнгөд үрэлгэн хандсан байна. Хэрэв анх техник, эдийн засгийн үндэслэлээр тооцсон 60 кВт-ын хүчин чадалтай нарны цахилгаан станцыг 807.2 сая төгрөгөөр барихаар баталсан бол Цэцэг сум нэг нарны цахилгаан станцыг 2 өөр компаниар 1175.0 сая төгрөгөөр хийлгэхэд хүрэхгүй байжээ.

Техник, эдийн засгийн үндэслэл нь ажлын зураг, төсөв зохиох суурь болдог бөгөөд цаг хугацаа өнгөрөхийн хэрээр хөрөнгө оруулалтын тооцоо үнийн өөрчлөлтийн улмаас бодитой бус болж байна.

Тухайлбал, “Баясал төгс” ХХК-ийн хийсэн Өндөрхаан-Баруун-Уртын 110 кВт-ын 214.5 км урт цахилгаан дамжуулах агаарын шугамын техник, эдийн засгийн үндэслэлийн 4850.0 сая төгрөгөөр хэрэгжүүлэх хувилбарыг салбарын шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн хурлаас 2004 оны 2 дугаар сард дэмжсэн байна.

Техник, эдийн засгийн үндэслэл хийгдээд удсан байдлыг харгалзан үзэж Эрчим хүчний судалгаа хөгжлийн төв 2005 оны 7 сард ТЭХЯ-д уг цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын барилга угсралтын ажлын төсөвт өртгийг 5980.0 сая төгрөгөөр шинэчлэн тооцоолж хүргүүлснийг Засгийн газрын 2006 оны 19 дүгээр тогтоолоор хасч 4850.0 сая төгрөгөөр тогтоож, үүнээс 2006 онд 2000.0 сая төгрөг олгохоор баталсан байна.

Нээлттэй тендерт оролцогчдын үнийн санал дээрх төсөвт өртгөөс 17- 40 хувиар давсан тул Сангийн болон Түлш, эрчим хүчний сайдын тушаалаар төслийн өртгийг 6500.0 сая төгрөг болгон өөрчилж хязгаарлагдмал тендер зарлан 2006 оны 12 дугаар сарын 26-ны өдөр гүйцэтгэгчтэй гэрээ хийснээс цаг хугацаа алдаж, газар шорооны ажил хийх боломжгүй болж хүйтэрсэн бөгөөд төсөлд зориулсан мөнгө өөр төслийн санхүүжилтэд шилжиж, уг төслийн гүйцэтгэгчид 200.0 сая төгрөг олгогджээ.

Худалдан авах ажиллагааны төлөвлөлт, зохион байгуулалтын буруугаас оны сүүлчээр Сангийн сайд, салбарын сайд нар хамтарсан тушаал гаргаж олон төслийн санхүүжилтийг өөр хооронд нь гүйлгэж төсвийн зохицуулалт хийснээс төсвийн ерөнхийлөн захирагчдын худалдан авах ажиллагааны зорилт нэр төрлөөрөө биелээгүй байна.

Засгийн газрын 2006 оны 19 дүгээр тогтоолын 3-т “Төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн явц, ашиглалтад оруулах хугацаа, тэргүүлэх ач холбогдлыг харгалзан шаардлагатай гэж үзвэл төсвийн ерөнхийлөн захирагчдын саналыг үндэслэн энэ тогтоолоор батлагдсан хөрөнгийн дүнд багтаан зохицуулалт хийж ажиллахыг Сангийн сайдад зөвшөөрсүгэй” гэж заасан нь ийм боломж олгосон бөгөөд зүй нь төсвийн тодотголоор УИХ-ын шийдэх асуудал байжээ.

Тухайлбал, Сангийн сайд, ТЭХ-ний сайдын 2006 оны 268/76, 374/114, 404/121 дугаар тушаалуудаар 10432.4 сая төгрөг, Сангийн сайд, БСШУ-ны сайдын 2006 оны 244/275, 327/357, 344/388 дугаар тушаалуудаар 1024.6 сая төгрөг, Сангийн сайдын 2006 оны 151 дүгээр тушаалаар 638.5 сая төгрөгийн санхүүжилтийг өөр хооронд нь шилжүүлсэн байна.

Бүлэг 2

Төсвийн ерөнхийлөн захирагчид худалдан авах ажиллагааг хуулийн дагуу хэрэгжүүлээгүй байна

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлд зааснаар харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаараас давсан худалдан авалт хийх бол захиалагч хуулийн энэ зүйлд заасан нөхцөл шалгуурын дагуу тендерийн үнэлгээний хороог байгуулах ажлыг зохион байгуулах ёстой.

Сангийн сайд 2007 оны 81 дүгээр тушаалаар “Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагааг зохицуулах журам”, “Үнэлгээний заавар”, “Тендерт оролцогчид давуу эрх олгох аргачлал”-ыг тус тус баталжээ.

БХЯ-ны үнэлгээний хороог Төрийн нарийн бичгийн даргын 2006 оны 14 дүгээр тушаалаар байгуулсан ба жилийн турш хийгдсэн бүх худалдан авах ажиллагааг энэ хороо зохион байгуулсан нь дээрх хууль, тогтоомжтой зөрчилдөж байна. Энэ нь зарим хүмүүсийг үндсэн ажлаас нь хөндийрүүлээд зогсохгүй элдэв хэл аманд өртөх боломж нөхцөл бүрдүүлжээ.

Харин бусад яамд шинэ хуулийн дагуу тендер тус бүрд үнэлгээний хороо байгуулж, худалдан авах ажиллагааг зохион байгуулжээ.

Зарим захиалагч худалдан авах ажиллагааны нээлттэй, ил тод байх зарчмыг алдагдуулсан байна

Сангийн яамны ХААБЗГ “Цахим сүлжээнд тендерийн зар, үр дүнг зарлан мэдээлэх тухай” журмыг Сангийн сайдын 2006 оны 55 дугаар тушаалаар батлуулж, цахим сүлжээнд зар мэдээ тавих тухай сургалтыг зохион байгуулсны гадна худалдан авах ажиллагаанд оролцогч 100 гаруй байгууллагад мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлжээ.


Гэвч аудитын явцад хийсэн судалгаанд оролцогчдын дөнгөж 18,5 хувь нь тухайн жилд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний жагсаалтыг нийтэд зарлан мэдээлсэн байна. Өөрөөр хэлбэл төсвийн ерөнхийлөн захирагч нар худалдан авах ажиллагааны ил тод байх зарчмыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Судалгаанд хамрагдсан 22 төсвийн ерөнхийлөн захирагч 169,1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар төлөвлөснөөс 2006 онд 82,8 тэрбум төгрөгийн санхүүжилт хийхээр

батлагдаж, гүйцэтгэлээр 75,3 тэрбум төгрөгийн санхүүжилт олгожээ.

Худалдан авах ажиллагааны бүтэц

/сая төгрөг/



Дээрх худалдан авалтад ямар журмыг сонгож хэрэгжүүлснийг нэгтгэн харуулбал:

(сая төгрөгөөр)

Худалдан авах ажиллагааны арга	Бараа	Ажил	Үйлчилгээ	Дүн
Нээлттэй	34,000.3	16,632.5	3,960.0	54,592.8
Хязгаарлагдмал	4,646.4	643.9	-	5,290.3
Харьцуулалт	3,488.3	4,154.6	13.7	7,656.6
Шууд гэрээ	6,050.5	1,827.6	37.7	7,915.8
Гэрээгүй	65.1	-	2.2	67.3
Нийт дүн	48,250.6	23,258.6	4,013.6	75,522.8

2006 оны худалдан авах ажиллагааны төсвийг гүйцэтгэлтэй нь харьцуулбал 7,5 тэрбум төгрөгийн дутуу гүйцэтгэл гарсан байна.

Судалгаанд хамрагдсан байгууллагуудын худалдан авалтын жагсаалт, тендер шалгаруулалтын журмыг хэрхэн сонгож хэрэгжүүлсэн талаархи судалгааг Хавсралт № 2-оор үзүүлэв.

Засгийн газрын 2006 оны 22 дугаар тогтоолоор батлагдсан “Худалдан авах ажиллагаанд мөрдөх журмыг сонгоход баримтлах босго үнэ”-ийн дагуу захиалагч 1.0 сая хүртэлх төгрөгийн үнэ бүхий барааг шууд худалдан авч болох бөгөөд 30.0 сая төгрөг хүртэл бараа, 50.0 сая төгрөг хүртэл үнэ бүхий ажлын хувьд харьцуулалтын аргаар, үүнээс бусад тохиолдолд хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын аргаар гүйцэтгэгчийг сонгох ёстой.


Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага зөвшөөрөл олгох төсөвт өртгийн доод хязгаарыг барааны хувьд 800.0 сая төгрөг, ажлын хувьд 1.0 тэрбум төгрөг, зөвлөх үйлчилгээний хувьд 200.0 сая төгрөг, бусад үйлчилгээний хувьд 800.0 сая төгрөг байхаар тогтоосон байна.

Захиалагч нар нээлттэй тендер шалгаруулах ёстой худалдан авалтыг хуульд заасан тендер шалгаруулалтын онцгой журам хэрэглэх нөхцөл бүрдээгүй байхад хязгаарлагдмал тендер шалгаруулалт, харьцуулалт, шууд гэрээ байгуулах аргаар гүйцэтгэгчийг сонгож, хууль зөрчих явдал нийтлэг байна.

Судалгаанд хамрагдсан 50 байгууллагын 2006 онд хийхээр төлөвлөсөн нийт 82.8 тэрбум төгрөгийн худалдан авалтын 86.5 хувийг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар, 13.5 хувийг харьцуулалт болон бусад аргаар хийх ёстойгоос, гүйцэтгэлээр 75.3 тэрбум төгрөгийн худалдан авалт хийж, түүний 75.0 хувийг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар, 7.0 хувийг хязгаарлагдмал тендер шалгаруулалтын аргаар, 10 хувийг харьцуулалтын аргаар, үлдэх 8 хувийг шууд гэрээ байгуулах аргаар болон гэрээ байгуулалгүй худалдан авсан байна. (Хавсралт № 2-ыг үз)

Худалдан авалтын аргуудыг хэрэглэсэн байдал

/сая төгрөг/



Аудитад хамрагдсан байгууллагууд төсвийн хөрөнгөөр хийгдэх, түүний дотор урсгал зардлаас санхүүжих худалдан авалтад тендер зарлалгүй шууд гэрээ байгуулж Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг зөрчсөн тохиолдол нийтлэг байна. Тухайлбал:

- ТЭХ-ний сайдын багцын хувьд урсгал зардлаас санхүүжсэн 102,7 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга, хэрэгслийг шууд худалдан авалтын аргаар худалдаж авсан бөгөөд эдгээрийг 1 буюу 2 багц болгож нээлттэй тендер шалгаруулалтын аргаар худалдан авах ёстой байжээ.
- БХБ-ын сайдын багцын хувьд урсгал зардлаар 41,1 сая төгрөгийн тоног, төхөөрөмж худалдаж авсныг 1-2 багц болгон нээлттэй болон хязгаарлагдмал тендер шалгаруулах ёстой байжээ.
- БХЯ-ны хөрөнгө оруулалтаар Дархан-Уул аймаг дахь цэргийн дугаар ангийн барилга засварын ажлыг Барилгын цэргийн 017 дугаар ангиар хийлгэхээр 200,0 сая төгрөгийг шилжүүлжээ. Гэтэл 017 дугаар анги барилга засварыг хийлгүй, Жи-Эс ХХК-иар тендер зарлалгүй гүйцэтгүүлж “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах” тухай хуулийн 7.1-г зөрчсөн байна.
- ОБЕГ 2006 онд Дундговь аймгийн Онцгой байдлын хэлтсийн галын депогийн 300,0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй барилга бариулахаар “Өнө мөнх” ХХК-тай шууд гэрээ хийж 2006 онд 50,0 сая төгрөг, 2007 онд 80,4 сая төгрөг, бүгд 130,4 сая төгрөг шилжүүлсэн, Их тэнгэр цогцолбор “Бул бул” ХХК-иас 130.8 сая төгрөгийн үнэ бүхий 6.0 мянган тонн нүүрс авсан байна.
- ОБЕГ хөрөнгийн эх үүсвэр шийдэгдээгүй атал хувцасны зардал, нөөцийн барааны борлуулалтын орлого болон бусад зардлаас 396.8 сая төгрөгийн барилгын их засварыг 2004-2007 онд ЮБЛ ХХК-иар шууд гэрээ хийж гүйцэтгүүлсний дотор 2006 онд уулзалтын болон хурлын танхим, зарим өрөөнүүд, гадна фасадын зургийн 80.1 сая төгрөгийн 3 төсөв баталж, 78.8 сая төгрөгийн их засварын гүйцэтгэл гарч, ажил хүлээн авах актаар 59.7 сая төгрөгийн санхүүжилт олгожээ.
- БСШУЯ эмзэг бүлгийн хүүхдэд 792.6 сая төгрөгийн сурах бичиг, хичээлийн хэрэглэл шууд гэрээгээр худалдан авсан байна.
- Шударга бус өрсөлдөөнийг хянан зохицуулах газар Монгол Улсын Шадар сайд, Сангийн сайдын “Хөрөнгө зохицуулах тухай” 334 дүгээр тушаалаар их засварт зориулсан 15.0 сая төгрөгийг “Төсвийн хөрөнгөөр санхүүжих тоног төхөөрөмж” ангилалд шилжүүлэн шууд гэрээгээр автомашин худалдан авсан байна.
- ТӨХ 123.0 сая төгрөгийн, СЗХ 70.1 сая төгрөгийн, ШБӨХЗГ 25.0 сая төгрөгийн худалдан авалт хийсэн атлаа 2006 онд босго үнээс давсан худалдан авалт хийгээгүй гэж албан бичиг ирүүлсэн байлаа.

Зарим захиалагч Засгийн газраас тогтоосон босго үнээс давсан бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа тендер шалгаруулахгүй байгаа нь Сангийн яам, холбогдох төсвийн ерөнхийлөн захирагчид худалдан авах ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилтэд хяналт тавих үүргээ хангалтгүй биелүүлсэнтэй холбоотой байна.

2007 оны 2 дугаар сарын 6-ны өдөр УИХ-аас баталсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн 1.3-т Улсын төсвийн хөрөнгөөр барьж байгуулах авто зам, эрчим хүчний төслийн хөрөнгө оруулалтын хэмжээ нь тухайн чиглэлийн үйл ажиллагаа эрхэлдэг дотоодын нийт аж ахуйн нэгжүүдийн хүчин чадалтай тэнцүү буюу түүнээс хэтэрсэн тохиолдолд Засгийн газар жишиг үнийг үндэслэн гүйцэтгэгчдийг шууд

сонгохоор заасан нь худалдан авах ажиллагааны үндсэн зарчмуудтай зөрчилдөж байна.

Шинэ хуульд заасан худалдан авах ажиллагааны зарим хэлбэр хэрэгжээгүй байна

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45.4, 45.5, 45.6-д заасан тодорхой нэрийн болон нэг нэр төрлийн барааг хамтран ба нэгдсэн журмаар худалдан авах нь хэмнэлттэй бөгөөд үр ашигтай бол төвлөрүүлэх эсхүл хамтран худалдан авах ажиллагааг зохион байгуулж болох талаархи заалтууд хэрэгжээгүй байна. Энэ нь шинэ хууль 2006 оны 2 дугаар сарын 1-нээс хэрэгжсэнтэй холбоотой байж болох бөгөөд дээрх заалтыг зүй зохистой хэрэгжүүлсэн нөхцөлд төсвийн хөрөнгийг арвилан хэмнэх боломжтой юм.

ТЭХЯ нарны цахилгаан үүсгүүр нийлүүлэх тендерийн баримт бичгийг хангалтгүй боловсруулснаас гадна Сангийн яам “L systech” ХХК-тай гэрээ байгуулах байр суурьтай байжээ

Засгийн газрын 2006 оны 127 дугаар тогтоолоор “100.0 мянган нарны гэр” хөтөлбөрийн санхүүжилт шийдэгдсэнээс 2 сарын дараа 2006 оны 8 дугаар сарын 3-ны өдөр үнэлгээний хороо байгуулж, 2006 оны 8 дугаар сарын 30-ны өдөр 50 Вт хүчин чадалтай, 50000 ширхэг нарны цахилгаан үүсгүүр нийлүүлэх нээлттэй тендер шалгаруулалт зарлаж, сонин хэвлэлээр мэдээлжээ.

2006 оны 10 дугаар сарын 16-ны өдөр тендер нээхэд шаардлага хангасан (Захиалагчийн төсөвт өртөг 16.0 тэрбум төгрөг гэж тооцоолсон ба 6 компани 14-29 сая долларын үнийн санал ирүүлжээ) тендер ирээгүйгээс бүх тендерээс татгалзсан байна.

Сангийн сайд 2006 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр нарны цахилгаан үүсгүүрийн нийлүүлэлт нь бусад төслөөс онцлог ялгаатай учир хамгийн бага үнийн санал ирүүлсэн “L systech” ХХК-тай (захиалагчийн төсөвт өртгөөс 8.2% хэтэрсэн) гэрээ байгуулж ажиллах нь зүйтэй гэсэн саналыг 9-11/4856 дугаар албан бичгээр Түлш, эрчим хүчний сайдад хүргүүлжээ.

Түлш, эрчим хүчний сайд “L systech” ХХК-тай гэрээ байгуулах боломжгүйг 2006 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр а/2106 дугаар албан бичгээр Сангийн сайдад мэдэгдэж, хязгаарлагдмал тендер шалгаруулалт зарлахыг зөвшөөрсөн байна. Ингээд тоо хэмжээг 21500 болгон дахин хязгаарлагдмал тендер шалгаруулалт зохион байгуулж Сангийн яамнаас урьд нь санал болгож байсан “L systech” компани шалгарч, гэрээ хийсэн боловч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйн улмаас гэрээ цуцлагдаж, хуулийн байгууллагад шилжээд байна.

Нээлттэй ба хязгаарлагдмал тендер шалгаруулалт амжилтгүй болж дахин тендер зарлах тохиолдолд өөр компани нэмэгдэж тендер ирүүлсэн тохиолдол маш цөөн байсан. Иймээс дахин нээлттэй тендер шалгаруулалт зохион байгуулах нь цаг хугацаа алдахаас өөр үр дүн багатай болох нь ажиглагдаж байна.

Өндөрхаан-Баруун-Уртын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын барилга угсралтын ажлын гүйцэтгэгч сонгох нээлттэй тендер хүчингүй болж, Сангийн болон ТЭХ-ний сайдын 2006 оны 374/114 дүгээр тушаалаар төслийн өртгийг 6500.0 сая төгрөг болгон өөрчилж хязгаарлагдмал тендер шалгаруулалт зарласнаар Дархан,

Сэлэнгийн цахилгаан дамжуулах сүлжээ ХК ялж, 2006 оны 12 дугаар сарын 26-ны өдөр гэрээ хийсэн байна.

Тендерт оролцогч гурван компанийн шалгаруулалт тус бүрд ирүүлсэн үнийн саналыг хүснэгтээр харуулбал:

(сая төгрөгөөр)

Тендерт оролцсон компанийн нэр	НТШ-д ирүүлсэн үнийн санал	ХТШ-д ирүүлсэн үнийн санал	Зөрүү
Дархан, Сэлэнгийн цахилгаан дамжуулах сүлжээ ХК	5 694 377 660	6 451 785 000	+757 407 340
Илч хангай ХХК	6 400 000 000	6 469 467 000	+69 467 000
М-Си-Эс ХХК	6794 821 000	6 784 728 000	+10 093 000

Дархан, Сэлэнгийн цахилгаан дамжуулах сүлжээ ХК анх нээлттэй тендер шалгаруулалтад уг ажлыг 5694.3 сая төгрөгт багтаан гүйцэтгэх бололцоотой гэж үзэн үнийн санал ирүүлж байсан бол тендерийн баримт бичигт өөрчлөлт оруулаагүй, өөрчлөлт хийвэл уг шугам, дэд станцыг ашиглах боломжгүй атал хоёрхон сарын дараа хязгаарлагдмал тендер шалгаруулалтад 6451.7 сая төгрөгийн үнийн санал ирүүлж ялснаар анхны үнийн саналаас 757.7 сая төгрөгөөр илүү үнэтэй гэрээ хийгджээ.

Хэрэв 2006 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд төслийн өртгийг Эрчим хүчний судалгаа, хөгжлийн төвийн төсөвлөсөн 5980.0 сая төгрөгөөр баталсан бол анхны нээлттэй тендер шалгаруулалтын дүнд Дархан, Сэлэнгийн цахилгаан дамжуулах сүлжээ ХК 5694.3 сая төгрөгийн үнийн саналаар ялж дээрх 757.7 сая төгрөг улсын төсөвт үлдэх байжээ.

Улсын төсөвт эрчим хүч, зам гэх мэт том төслийг тусгахдаа техник, эдийн засгийн үндэслэл хийгдээд удсан тохиолдолд үнийн өөрчлөлтийг харгалзаагүйгээс 2006 оны 4 дүгээр сард эхэлсэн дээрх тендер шалгаруулалт 12 дугаар сард дуусаж гэрээ хийгдсэн нь ихээхэн цаг хугацаа, хүч хөдөлмөр үрсэн ажил болжээ.

Тендерийн хуучин хуулийн дагуу нээлттэй ба хязгаарлагдмал тендер шалгаруулалт зохион байгуулахад шаардлага хангасан тендер ирээгүй буюу эсхүл нэг ч тендер ирээгүй тохиолдолд шууд гэрээ байгуулах аргыг сонгож болдог байсан бол шинэ хуулиар шалтгааныг судлан дахин нээлттэй тендер зарлах болсон нь өрсөлдөөнийг дэмжсэн сайн талтай боловч авто зам, цахилгаан дамжуулах агаарын шугам зэрэг улирлын чанартай ажилд цаг хугацаа алдах, өвөл болсон хойно гэрээ хийгдэж төлөвлөсөн ажил тухайн жилд хийгдэхгүйд хүрэх нэг шалтгаан болж байна.

Худалдан авах ажиллагаанд оролцож байгаа боловсон хүчний мэдлэг, мэргэшил, тогтвор суурьшил, хариуцлага хангалтгүй байна

Худалдан авах ажиллагааг хууль, тогтоомжийн дагуу үр нөлөөтэй гүйцэтгэхэд худалдан авах ажиллагаанд оролцож байгаа боловсон хүчний асуудал чухал юм.

Тендерт оролцогчдын худалдан авах ажиллагааны талаархи мэдлэг, туршлага муу байгаагаас шаардлага хангаагүй тендер ирүүлэх нь түгээмэл байна.

Ингэснээр тодруулга авах, дахин тендер зохион байгуулах зэргээр хугацаа алдах, өчүүхэн жижиг алдаанаас болж тендерээс хасагдах явдал гарч байна.

Иймд худалдан авах ажиллагааны талаар сургалт сурталчилгааг өргөн зохион байгуулах шаардлагатай байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 49 дүгээр зүйлд заасанчлан захиалагч худалдан авах ажиллагаа явуулсан тухай бүр тендер шалгаруулалтын хавтаст хэрэг бүрдүүлж архивын нэгж болгон хадгалах ёстой.

Судалгаанд хамрагдсан 50 байгууллагын 92.9 хувь нь тендер шалгаруулалтын хавтаст хэрэг бүрдүүлж архивын нэгж болгон хадгалсан гэж мэдээлсэн боловч 15 байгууллагын баримт материалыг газар дээр нь шалгахад бичиг баримтыг зохих ёсоор бүрдүүлж, архивын нэгж болгосон байгууллага нэг ч байсангүй.

Захиалагч байгууллагууд ирсэн бүх тендерийг хадгалалгүй зөвхөн шалгарсан тендерийг хадгалсан, худалдан авах ажиллагаатай холбоотой баримт материалууд нэг дор биш өөр газарт архивлагдсан, гэрээ байгуулах хүртэлх материалыг хадгалсан, дараагийн материал дутуу байсан зэрэг зөрчил илэрлээ. Тухайлбал, Эрчим хүчний судалгаа хөгжлийн төв, Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн үндэсний төв, ЗТАЖЯ-ыг дурдаж болох юм.

БСШУЯ-ны Барилга захиалагчийн алба тендерийн материалыг үдэж цэгцэлсэн боловч архивын нэгж болгоогүй, зарим материал дутуу байлаа.

НХХЯ-наас 2006 онд хийгдсэн 9 худалдан авалтаас иж бүрэн тендерийн баримт материалын хавтаст хэрэг байхгүй байлаа.

Тендерийн баримт материалын бүрдүүлэлт, хадгалалт, хамгаалалт хангалтгүй байгаа нь байгууллага, албан тушаалтнуудын ажлын зохион байгуулалт, хариуцлага сул байгаагаар холбоотой байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 49 дүгээр зүйл, Сангийн сайдын 2006 оны 396 дугаар тушаалаар батлагдаж, 2007 оны 1 дүгээр сард шинэчлэгдсэн “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг тайлагнах” журмын дагуу

төсвийн ерөнхийлөн захирагч нар 2006 оны худалдан авах ажиллагааны тайланг 2007 оны 1 дүгээр сарын 15-ны дотор Сангийн яаманд ирүүлэх ёстой.

Гэтэл Шадар сайдын төсвийн багцад хамаарах байгууллагууд болон Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах комисс 2006 оны худалдан авах ажиллагааны тайланг огт ирүүлээгүй бөгөөд ХЗДХ-ийн, ГХ-ийн, Сангийн, ЗТАЖ-ын, ХХАА-н, ҮХ-ны, БСШУ-ны, ЭМ-ийн, НХХ-ийн сайд зэрэг 23 төсвийн ерөнхийлөн захирагч тайланг хугацаа хоцроосон байна.

БХЯ-ны тайлангаас бусад нь шаардлагатай мэдээллийг бүрэн тусгаагүйн гадна тайланг буруу гаргаж өгчээ.

Аудитын явцад Сангийн яаманд бусад яамдаас ирүүлсэн худалдан авах ажиллагааны тайланд тусгагдсан зарим үзүүлэлтийг үндсэн баримттай нь тулган шалгахад зөрүүтэй байлаа.

- СЭХҮТ-ийн Ховд аймгийн Цэцэг суманд барьж буй 30 кВт-ын нарны цахилгаан станцыг 2007 оны 5 дугаар сарын 31-ний өдөр, 50 Вт-ын 21500 ширхэг нарны цахилгаан үүсгүүр нийлүүлэх гэрээг 2007 оны 5 дугаар сарын 1-ний өдөр дүгнэсэн гэж тайлагнасан боловч уг станц одоогоор дуусаагүй, өөр компанитай нэмэлт гэрээ хийж өргөтгөж байгаа, нарны үүсгүүрийн гэрээ биелэгдэхгүйд хүрч зогссон байна. Мөн бусад салхин цахилгаан станц барих гэрээт ажил 2007 оны 6,7 дугаар сард гэрээ дүгнэснээр тайлагнасан ч 2007 оны 9-10 сард Улсын комиссын акт гарч гэрээ дүгнэгдсэн байна.
- ОБЕГ Дундговь аймгийн Онцгой байдлын хэлтсийн галын депо барьж буй “Өнө мөнх” ХХК-тай байгуулсан гэрээг 2007 оны 10 дугаар сарын 25-нд дүгнэсэн мэтээр 2007 оны 1 дүгээр сарын 3-ны өдөр тайлагнасан байна.
- ОБЕГ “Эйч энд Эйч” ХХК-тай байгуулсан хорт утааны баг нийлүүлэх тухай гэрээг Сангийн яаманд ирүүлсэн худалдан авах ажиллагааны тайланд 2006 оны 10 дугаар сарын 23-ны өдөр дүгнэж, тооцоо дууссан мэтээр тайлагнасан боловч гэрээний хэрэгжилтийг газар дээр шалгахад гэрээг дүгнээгүй байна.

Сангийн яамны Худалдан авах ажиллагааны бодлого зохицуулалтын газраас төсвийн ерөнхийлөн захирагчдын 2006 онд хийсэн худалдан авалтын төлөвлөгөө, тайлан, худалдан авах ажиллагааны цахим хуудаст нийтлэгдсэн тендер шалгаруулалтын урилга, үр дүн, 2006 онд Сангийн яамнаас зөвшөөрөл олгосон худалдан авах

ажиллагааны судалгаа, тендерт оролцогчдоос гаргасан гомдлын судалгаанд үндэслэн худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд үнэлгээ өгсөн байна.

Үүнд нийт авбал зохих 100 онооноос ерөнхийлөн захирагчдын үнэлгээ дунджаар 54 оноо байсан бөгөөд БХЯ 77 оноо, БСШУЯ 71 оноо, ХХААЯ 71 оноо авсан нь хамгийн өндөр оноо болжээ. ГХЯ 14 оноо, НХХЯ 36 оноо авсан нь хамгийн доогуур үзүүлэлт байна.

Сангийн яамнаас томилогдсон ажлын хэсэг 2006 оны худалдан авах ажиллагааг 14 аймагт үнэлснээс Өмнөговь, Дархан-Уул аймаг тэргүүлж, Булган, Дундговь аймгууд сүүлийн байранд орсон байна.

Бүлэг 3 Гэрээний хэрэгжилтэд тавих хяналт сул байна

Бараа, ажил, үйлчилгээний бэлтгэн нийлүүлэгч болон гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулах хүртэлх үйл ажиллагаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулиар зохицуулагдаж, гэрээ дүгнэх, түүний үр дүнг үнэлэх, хянах үйл явц бусад хууль эрхийн актаар зохицуулагдаж байна.

Аудитад хамрагдсан байгууллагууд худалдан авах ажиллагааны төсвийг гүйцэтгэлтэй нь харьцуулж үнэлэлт дүгнэлт өгөх, худалдан авах ажиллагааг зохион байгуулж байгаа хүмүүст хариуцлага тооцоогүй, худалдан авах ажиллагааны үр дүнг үнэлэх журам баталж мөрдөж буй байгууллагагүй байна.

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан боловч тайлант хугацаанд хэрэгжээгүй худалдан авалтыг хасч тооцвол 2006 онд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээнээс 1,142.4 сая төгрөг хэмнэгдсэн нь худалдан авалтын 1.5 хувьтай тэнцүү байна.

Гэвч аудитад хамрагдсан зарим байгууллагууд гүйцэтгэгч байгууллагатай хийсэн гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаагүйгээс хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагыг хангаагүй чанар муутай бараа, ажил, үйлчилгээ худалдан авч, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсны гадна гэрээний үүргээ биелүүлээгүй гүйцэтгэгчидтэй хариуцлага тооцоогүй байна. Тухайлбал:

- Засгийн газрын 2006 оны 60 дугаар тогтоолоор Ховд аймгийн Мөнххайрхан, Манхан сумдын УЦС-ыг сэргээн засварлахад 142.8 сая төгрөгийг Засгийн газрын нөөц хөрөнгөөс зарцуулжээ.

Уг УЦС-уудыг 1998-2003 онд улсын төсвийн хөрөнгөөр Ховд аймгийн “Тулга” ХХК барьж ашиглалтад оруулсан боловч 2005 онд үерийн улмаас усны түвшин өргөх далан сэтэрснээс ихээхэн хэмжээний хохирол учирсан байна.

ТЭХЯ, ОБЕГ-ын хамтарсан ажлын хэсэг, тус аймгийн барилгын техник хяналтын болон эрчим хүчний хяналтын улсын байцаагчдын энэ эвдрэлийн шалтгааныг тогтоосон дүгнэлтэд байгалийн гамшгаас гадна УЦС-ын зураг төслийг хийсэн “Ус эрдэнэ” ХХК, гүйцэтгэгч Ховд аймгийн “Тулга” ХХК-ийн ажлын хариуцлагатай холбоотой гэжээ. Өөрөөр хэлбэл тухайн үед барилга байгууламжийн ажил чанаргүй хийгдсэнээс төсвөөс их хэмжээний хөрөнгө дахин гаргаж, үргүй зарцуулсан байна.

- ОБЕГ-аас зохион байгуулсан тендерт шалгарсан “Эйч энд Эйч” ХХК-ийн нийлүүлсэн 91,5 сая төгрөгийн 144 ком хорт утааны баг чанарын шаардлага хангаагүйгээс ашиглах боломжгүй болж, төсвийн хөрөнгийг үр дүнгүй зарцуулжээ. Гэтэл тухайн компанитай хариуцлага тооцоогүй байна.
- “Жи Ти Эл” ХХК-иас ОБЕГ-т нийлүүлсэн 146.8 сая төгрөгийн тоног төхөөрөмжөөс 7.2 сая төгрөгийн өртөгтэй 12 компьютер, 34.0 сая төгрөгийн өртөгтэй 4 ширхэг радио станц, 340.0 мянган төгрөгийн өртөгтэй 2 ширхэг принтер эвдэрхий, ашиглах боломжгүй, техник хэрэгслийн зарим үзүүлэлт техникийн тодорхойлолтод заасан хүчин чадалд хүрэхгүй байна.

Зарим гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ хугацаандаа биелүүлэхгүй байгаа нь төрийн байгууллагын үйл ажиллагаанд хүндрэл учруулж байна. Тухайлбал:

- Дундговь аймгийн Онцгой байдлын хэлтсийн галын депо барьж буй “Өнө мөнх” ХХК гэрээ ёсоор барилгыг 2007 оны 10 дугаар сарын 25-нд хүлээлгэж өгөх байтал уг компани төлбөрийн чадваргүй болж одоо болтол хүлээлгэж өгөөгүй байна.
- Төрийн тусгай хамгаалалтын газар хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр худалдан авсан 9.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг Их тэнгэр цогцолборт хүлээлгэн өгөхөөс 6.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг хүлээлгэн өгч, 3.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг одоо хүртэл нийлүүлээгүй байна.
- ТЭХЯ-ны СЭХҮТ “L systech” ХХК-ийн хооронд 21500 ширхэг нарны үүсгүүрийг 2007 оны 5 дугаар сарын 1-ний дотор нийлүүлэх гэрээг 2006 оны 12 дугаар сарын 25-ны өдөр хийсэн ч уг гэрээ хэрэгжээгүй цуцлагджээ. Уг 21500 ширхэг нарны цахилгаан үүсгүүрийг 2006 онд нийлүүлсэн бол “100.0 мянган нарны гэр” үндэсний хөтөлбөрийн 2 дугаар үе шатны зорилт биелэх байсан.
- ОБЕГ “АО Жаргалант” ХХК- иас 403.1 тонн шатахуун, “Химийн шингэн” ХХК-иас 1198.3 тонн шатахуун, “Алтай таван богд хайрхан” ХХК-иас 618 тонн буюу 199,3 сая төгрөгийн улаан буудайг дутуу авсан байна.

ЗТАЖЯ, ТЭХЯ -наас бусад яамдын хувьд бараа худалдан авах гэрээг дүгнэж хариуцлага тооцоогүй байна.

Нарны цахилгаан үүсгүүрийн зарим хэсгийг дотооддоо үйлдвэрлэх боломжийг ашиглаагүй байна

1998 онд Азийн хөгжлийн банк, Нордикийн хөгжлийн сангаас жилийн 6.7 хувийн хүүтэй авсан зээлээс 525.0 мянган ам долларын өртөгтэй байгуулагдсан, жилд 10000 иж бүрдэл нарны цахилгаан үүсгүүр үйлдвэрлэх хүчин чадалтай нарны зайн үйлдвэр нь тухайн үед ШЦХГ-т харъяалагдаж байгаад 2005 онд бүтцийн өөрчлөлтөөр ТЭХЯ-ны харъяа Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төвд шилжиж ирсэн боловч одоогоор ашиглалтгүй, Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв, ТЭХЯ-ны санхүүгийн тайланд уг зээлийн өр тусгагдаагүй, зээлийн ашиглалт муу байна.

Засгийн газрын 2006 оны 127 дугаар тогтоолоор “100.0 мянган нарны гэр” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд 8.0 тэрбум төгрөгийн санхүүжилт шийдэгдсэнээс дөрвөн сар хагасын дараа 2006 оны 10 дугаар сарын 24-ний өдөр ТЭХ-ний сайдад Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төвөөс 5000 ширхэг нарны цахилгаан үүсгүүрийг Нарны зайн

үйлдвэрт үйлдвэрлэж малчдад нийлүүлэх талаар шийдвэр гаргаж өгөхийг хүссэн бичиг ирүүлсэн нь цаг хугацааны хувьд ихээхэн оройтсон, өөрөөр хэлбэл 2006 оны 8 дугаар сарын 30-ны өдөр 50 Втын хүчин чадалтай 50000 ширхэг нарны цахилгаан үүсгүүр нийлүүлэх нээлттэй тендер шалгаруулалт зарлагдаж, тендерийн үнэлгээ хийгдэж байсан үе ажээ.

Гэсэн ч нээлттэй тендер шалгаруулалтыг хүчингүй болгож, тоо хэмжээг 21500 болгож өөрчлөн хязгаарлагдмал тендер шалгаруулалт зарлах үед энэ асуудлыг авч үзэж болох байжээ.

ҮАГ-аас 2004 онд Тендерийн холбогдолтой хууль тогтоомжийн хэрэгжилтэд хийсэн аудитаар Санхүү, эдийн засгийн, Боловсрол, соёл, шинжлэх ухааны, Дэд бүтцийн, Эрүүл мэндийн, Хүнс, хөдөө аж ахуйн сайд нарт 4, ХХАА-н сайдад 1, БСШУ-ны сайдад 2, нийт 7 зөвлөмж өгсөн нь 43 хувийн биелэлттэй байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчдад хүргүүлсэн худалдан авах ажиллагааны талаархи судалгааг зарим яам, байгууллагууд хугацаанд нь үнэн зөв, иж бүрэн гаргаж ирүүлээгүй нь аудитын явцад ихээхэн хүндрэл учрууллаа. Тухайлбал, БСШУЯ, ТӨХ, ОБЕГ, ШБӨХЗГ зэрэг байгууллагыг дурдаж болно.

Дүгнэлт

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараахь дүгнэлт гаргаж байна. Үүнд:

1. Ихэнх захиалагч худалдан авах бараа, ажил, үйлчилгээг батлагдсан төсөвт багтаан үр ашигтай төлөвлөж, зохион байгуулаагүй, худалдан авах бараа, ажил, үйлчилгээний жагсаалтыг нийтэд зарлан мэдээлэх үүргээ зохих ёсоор биелүүлээгүй, худалдан авах ажиллагаанд хяналт тавиагүй, хууль тогтоомж зөрчсөн этгээдэд зохих арга хэмжээ аваагүй байна.
2. Зарим захиалагч Засгийн газраас тогтоосон босго үнээс давсан бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа тендер шалгаруулалгүй гүйцэтгэгчийг сонгож хууль зөрчиж байна.
3. Зарим салбарын гүйцэтгэгчийг шууд сонгохоор хуульчилсан нь худалдан авах ажиллагааны үндсэн зарчмуудтай зөрчилдөж байгаагийн дээр тендер зарлах, ирүүлэх, үнэлэх, шалгаруулах ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх замаар улам боловсронгуй болгож худалдан авах ажиллагааны ил тод байх зарчмыг хэрэгжүүлэх шаардлагатай байна.
4. Захиалагч нар худалдан авах ажиллагааг хугацаанд нь тайлагнах, тендерийн баримт бичгийг хавтаст хэрэг болгон бүрдүүлж архивын нэгж болгон хадгалах үүргээ хангалтгүй биелүүлж байна.
5. Захиалагч нар гэрээний үүргээ биелүүлээгүй гүйцэтгэгчидтэй хариуцлага тооцож ажиллаагүйгээс төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулж, байгууллага, иргэд хохирсон байна.
6. Судалгаанд хамрагдсан төсвийн ерөнхийлөн захирагч нар 2006 онд зарцуулахаар батлагдсан төсвийн 90.9 хувийг ашигласан, үлдэх 9.1 хувь буюу 7.5 тэрбум төгрөг ашиглах боломжийг алдсан нь захиалагч нарын ажлын зохион байгуулалтаас гадна гүйцэтгэгч нарын хүчин чадалтай холбоотой байна.

Аудитын зөвлөмж

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Сангийн сайд Ч.Улаанд зөвлөмж болгож байна:

1. Төсвийн ерөнхийлөн захирагчдын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хугацаанд нь хүлээн авч нэгтгэн, үнэлэлт дүгнэлт өгч, түүний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах, хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ, барилга байгууламжийн төсвийг төлөвлөхдөө техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөвт үндэслэх, зураг төсөвгүй арга хэмжээнд төсөв батлахгүй байх.
2. Төсвийн ерөнхийлөн захирагчидтай хамтран захиалагч байгууллагын тендерийн баримт материалын боловсруулалт, бүрдүүлэлт, шалгаруулалт, хадгалалт хамгаалалт, худалдан авах ажиллагааны тайлагналд шалгалт хийж, холбогдох арга хэмжээ авах.
3. Улсын төсвийн хөрөнгөөр барьж байгуулах авто зам, эрчим хүчний төслийн хөрөнгө оруулалтын хэмжээ тухайн чиглэлийн үйл ажиллагаа эрхэлдэг дотоодын нийт аж ахуйн нэгжүүдийн хүчин чадалтай тэнцүү буюу түүнээс хэтэрсэн тохиолдолд Засгийн газар жишиг үнийг үндэслэн гүйцэтгэгчдийг шууд сонгохоор Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд шинээр орсон заалтыг өөрчлөх, тендер зарлах, ирүүлэх, үнэлэх, шалгаруулах ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх замаар улам боловсронгуй болгох асуудлыг судалж, зохих журмын дагуу шийдвэрлүүлэх.
4. Худалдан авах ажиллагааны талаархи сургалт сурталчилгааг эрчимжүүлэх.
5. Худалдан авах ажиллагааны үр дүнг гэрээ тус бүрээр төсөв, гүйцэтгэлийг харьцуулан үнэлэлт, дүгнэлт өгөх аргачлал боловсруулж мөрдүүлэх.

Холбогдох байгууллагын санал

ГЫН



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Нагдсан үндэстний гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас/факс: 26-02-47, http://www.mof.gov.mn

2007.01.18 № 9-11/296
танай 2007.01.08-ны № 1/06 -Т

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ОРЛОГЧ
Б.БАТБАЯР ТАНАА

Санал өгөх тухай

Төсвийн ерөнхийлөн захирагчдын 2006 оны худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлангийн төсөлтэй танилцаад дараах саналтай байна.

ҮАГ-ын тайлбар 1-ийг
үзнэ үү

1. Тус тайланд хууль зөрчсөн тухай бодитой жишээ оруулж өгсөн хэдий ч тэдгээр нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /цаашид "хууль" гэх/-ийн аль заалтыг зөрчсөн нь тодорхой бус байгаа тул зөрчигдсэн хуулийн заалт бүрийг тодорхой зааж өгөх нь зүйтэй байна.

ҮАГ-ын тайлбар 2-ыг
үзнэ үү

2. Шалгалтын тайлангийн 14 дүгээр хуудасны 4 дэх догол мөргыг хасах саналтай байна. Хуулийн 30.4.1-ийн дагуу дахин нээлттэй тендер шалгаруулалт зарлах нь тухайн жилд ажил хийгдэхгүй байх үндэслэлтэй шалтгаан биш гэж үзэж байна. Харин захиалагч худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зөв, оновчтой төлөвлөж, хуулийн 46.1.8-д заасны дагуу 1 сарын 15-ны дотор эхлүүлэн зохион байгуулахгүй байгаатай холбоотой юм.

ҮАГ-ын тайлбар 3-ыг
үзнэ үү

3. Тайлангийн дүгнэлт хэсгийн эхний заалтыг "Ихэнх захиалагч худалдан авах бараа, ажил, үйлчилгээг батлагдсан төсөвт багтаан үр ашигтай төлөвлөж, зохион байгуулаагүй, худалдан авах бараа, ажил, үйлчилгээний жагсаалтыг нийтэд зарлан мэдээлэх үүргээ зохих ёсоор биелүүлээгүй, худалдан авах ажиллагаанд хяналт тавьж ажиллаагүй, хууль тогтоомж зөрчсөн этгээдэд зохих арга хэмжээ аваагүй байна" гэж өөрчлөх.

ҮАГ-ын тайлбар 4-ийг
үзнэ үү

4. Зөвлөмж хэсэгт "Улсын төсвийг бодитой, үр ашигтай болгох үүднээс Засгийн газрын хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ, барилга байгууламжийн төсвийг төлөвлөхдөө тухайн арга хэмжээний техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөвт үндэслэх, зураг төсөвгүй төсөл арга хэмжээнд төсөв батлахгүй байх асуудлыг боловсронгуй болгох шаардлагатай байна" гэсэн заалт оруулах.

ҮАГ-ын тайлбар 5-г
үзнэ үү

5. Үндэсний аудитын газар нь шалгалтыг үр дүнтэй хийж ихээхэн зөрчил илрүүлсэн нь тайлангаас харагдаж байна. Харин тайландаа төсвийн ерөнхийлөн захирагч нарын гаргасан алдааг зөвхөн дурдан өнгөрөх бус зөрчил илэрсэн байгууллагуудад хугацаатай үүрэг өгөх, тэдэнд арга хэмжээ авах, хариуцлага тооцох зэрэг хуулиар ногдуулсан эрх үүргийнхээ дагуу шалгалтын үр дүнд үндэслэн тухайн ажлыг сайжруулах чиглэлээр авч хэрэгжүүлэх доривтой арга хэмжээг тусгах нь зүйтэй байна.

6. Шалгалтын тайлангийн дүгнэлтээр хуулийн хэрэгжилт, түүнд тавигдаж буй хяналт сул, хангалтгүй байгаа талаар дурдсан байна. Хуулинд 2005 оны 12 дугаар сард нэмэлт, өөрчлөлт орж 2006 оноос эхлэн Засгийн газрын худалдан авах ажиллагааг хэрэгжүүлэх бүтцийг өөрчилсөн. Шинэчлэн батлагдсан хуулийн дагуу

08 462

худалдан авах ажиллагааг тухайн төсвийн ерөнхийлөн захирагч, байгууллагууд бие даан явуулахаар төвлөрсөн бус тогтолцоотой болсноор хоёр жил гаруй боллоо. Энэ хугацаанд хууль хэрэгжүүлэхтэй холбоотой худалдан авах ажиллагааны үүрэг, хариуцлагыг оновчтой болгох, худалдан авах ажиллагааны төлөвлөлт, тайлагналын тогтолцоо зэрэг шинэлэг арга хэмжээнүүд үр дүнгээ өгч байна. Гэсэн хэдий ч хуулийг хэрэгжүүлэх явцад сөрөг үр дагаврууд ихээр гарч байгаа бөгөөд энэ талаар танай тайланд дурьдагдсан байна. Хэдийгээр Монгол улсын төсөв жил ирэх тусам өсч байгаа боловч Засгийн газрын худалдан авах ажиллагааг цомхон, үр ашигтай, ил тод, хуулийн дагуу зохион байгуулах боломж байгаа болно.

Иймд танай байгууллагын зүгээс Засгийн газрын худалдан авах ажиллагаанд хөндлөнгийн аудит хийсний хувьд худалдан авах ажиллагаа явуулж буй өнөөгийн бүтэц, зохион байгуулалт, хариуцлагын тогтолцоо болон цаашид Засгийн газрын худалдан авах ажиллагааг хэрхэн оновчтой, үр ашигтай явуулах талаар бодлогын хэмжээнд дүгнэлт гаргахыг хүсэж байна.



Ch. Ulaan

Ч.УЛААН



**МОНГОЛ УЛСЫН
ТҮЛШ, ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМ**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Нэгдсэн үндэстний гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас/Факс: 31-81-69

2008.01.21 № а/155
танай 08/Т -ны № 1107 -т

**МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ
АУДИТЫН ГАЗАРТ**

Үндэсний аудитын газраас Төсвийн ерөнхийлөн захирагчдын 2006 оны худалдан авах үйл ажиллагаанд хийсэн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Түлш, эрчим хүчний яам болон Эрчим хүчний судалгаа, хөгжлийн төв, Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төвийн 2006 онд худалдан авсан бараа, ажил үйлчилгээний тендерийн холбогдолтой баримт материалд хийсэн аудитын тайлан, дүгнэлттэй санал нэг байна.

Цаашид тайланд тусгагдсан зөрчил дутагдлыг давтахгүй байх, тендерийн баримт материалын боловсруулалт, бүрдүүлэлт, шалгаруулалт, хадгалалт, хамгаалалт, худалдан авах ажиллагааны тайлагнал, үр дүнд онцгой анхаарч түүний хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулж ажиллах болно.



ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ГАЗРЫН ДАРГА Я.НЯМЖАРГАЛ

[Handwritten signature]

0900111

Үндэсний аудитын газрын тайлбар

Сангийн яамнаас ирүүлсэн саналд өгөх тайлбар

Тайлбар 1

Тайланд дурдагдсан жишээ баримтууд тайлангийн тухайн бүлэгт хамаарч хуулийн тэр хэсгийн заалттай холбоотой тул жишээ бүрийн ард хуулийн заалтыг нэг бүрчлэн дурдах шаардлагагүй гэж үзлээ.

Тайлбар 2

Тендер шалгаруулалт хүчингүй болж дахин нээлттэй тендер зарлахад гол төлөв анхны оролцогчид тендер ирүүлдэг ба эдгээрээс өөр өрсөлдөгч нэмэгдэж тендер ирүүлэх тохиолдол цөөн байсан нь аудитын явцад харагдсан тул тайланд засвар хийх шаардлагагүй байна.

Тайлбар 3

Саналыг харгалзаж үзсэн.

Тайлбар 4

Саналыг хүлээн авч тусгав.

Тайлбар 5

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48.4-т “Төсвийн ерөнхийлөн захирагчийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, түүний хэрэгжилтэд төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хяналт тавьж үнэлгээ хийнэ” гэж Сангийн яамны хяналт тавих үүргийг заасан байна. Тус аудит нь УИХ-ын Төсвийн Байнгын хорооны саналаар зөвхөн улсын төсвөөс санхүүжсэн Төсвийн ерөнхийлөн захирагчдын худалдан авалтын хүрээнд хийгдсэн тул хуулийн 45.3-т заасан захиалагчдын худалдан авалт хамрагдаагүй тул танай саналд дурдсан дүгнэлт гаргах боломжгүй байна.

Худалдан авах ажиллагаанд н өрдөх журм ыг сонгоход баримтлах босго үнээс давсан зарлагын гүйлгээний нэгтгэл

Аудлын код: УАГ-1/2007/04ГА

№	Байгууллагын нэр	Гүйцэтгэгч сонгосон арга	Урсгал зардал		Хөрөнгө оруулалт		Бусад		Бүгд дүн		Нийт худалдан авалт	Эзлэх хувь												
			Барээ	Ажил	Барээ	Ажил	Барээ	Ажил	Барээ	Ажил			Үйлчилгээ											
1	Стандартчилал хэмжээний зүйл төв	Төндөр шалгаруулалт	18.40																					
													Нээлтэй											
													Хязгаарлагдмал											
													Харьцуулалт	19.80									19.8	0.03
2	Үндэсний статистикийн газар	Төндөр шалгаруулалт																						
													Нээлтэй											
													Хязгаарлагдмал	28.96										
													Харьцуулалт	16.60										16.6
3	Түлш эрчим хүчний яам, Эрчим хүчний судалгаа хөгжлийн төв	Төндөр шалгаруулалт																						
													Нээлтэй	7,122.80	164.60									
													Хязгаарлагдмал	2,363.60										
													Харьцуулалт	85.92										85.915
4	Мэргэжлийн хяналтын газар	Төндөр шалгаруулалт	48.50																					
													Нээлтэй	108.00										
													Хязгаарлагдмал											
													Харьцуулалт	16.80	25.00									90.3
5	Байгаль орчны яам	Төндөр шалгаруулалт																						
													Нээлтэй											
													Хязгаарлагдмал											
													Харьцуулалт	295.80	147.87									443.67
6	Бэрлэг хот байгууллагын яам	Төндөр шалгаруулалт																						
													Нээлтэй	4,772.34										
													Хязгаарлагдмал											
													Харьцуулалт	295.80	147.87									443.67
7	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам	Төндөр шалгаруулалт																						
													Нээлтэй	4,772.34										
													Хязгаарлагдмал											
													Харьцуулалт	295.80	147.87									443.67
8	Үйлдвэр худалдааны сайд	Төндөр шалгаруулалт																						
													Нээлтэй	177.80										
													Хязгаарлагдмал											
													Харьцуулалт	77.80	87.10									164.9
9	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны сайд	Төндөр шалгаруулалт																						
													Нээлтэй	8.60	738.10									
													Хязгаарлагдмал											
													Харьцуулалт	463.30	167.00									641.9
10	Хөдөлмөрийн яамны сайд	Төндөр шалгаруулалт																						
													Нээлтэй	10.00										
													Хязгаарлагдмал											
													Харьцуулалт	15.70	314.50									336.2
11	Хөдөлмөрийн яамны сайд	Төндөр шалгаруулалт																						
													Нээлтэй	10.00										
													Хязгаарлагдмал											
													Харьцуулалт	15.70	314.50									336.2

Худалдан авах ажиллагаанд мөрдөх журмыг сонгоход баримтлах босго үнээс давсан зарлагын гүйлгээ

Хөрөнгийн эх үүсвэр	Төсөвт өртөг (сая.төг)			Сонгох ёстой тендер шалгаруулалтын хурам			Сонгосон тендер шалгаруулалтын хурам				Тендер шалгаруулалтын хурмыг өөрчилсөн						
	Нийт дүн	2006 онд		Нээлттэй тендер	Тендер шалгаруулалтын онцгой хурам		Нээлттэй тендер	Тендер шалгаруулалтын онцгой хурам		Дүн	Шалгаан						
		Батлагсан	Гүйцэтгэл		Зөрүү	Хэсэглэгдсэн тендер		Харцуулалт	Хэсэглэгдсэн тендер		Харцуулалт	Шууд гарээ	Хэсэглэгдсэн тендер зарлагын	Үнийн харцуулалт	Хэсэглэгдсэн тендер зарлагын	Шууд гарээ	
А	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17
Стандартчилал хэмжил зүйн			42.6	41.4	1.2	0.0	0.0	41.4	0.0	0.0	19.8	21.6	0.0	0.0	0.0	0.0	0.0
1 төв	45.9	45.9	45.9	45.95	0.35	45.55	0	0	0	28.95	0	16.6	0	0	0	0	0
2 Статистикийн төв газар	31,249.3	14,030.7	14,030.7	10,840.8	3,189.9	13,989.9	0.0	40.8	7,277.4	2,353.6	85.9	1,123.9	3,375.1	4,934.8	64.8	1,123.9	0.0
3 Тууш эрчим хүчний яам	198.8	198.8	198.8	198.55	0.25	198.00	0.00	90.80	108.00	0.00	90.80	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
4 Мэргэжлийн хяналтын газар	0	565	563.37	563.37	1.63	193.7	0	443.67	193.7	0	443.67	0	0	0	0	0	0
5 Байгаль орчны яам	6798.025	6798.025	6798.025	7290.1	-492.08	4592.6	2697.5	2697.5	4592.6		1855.3	842.2	0	0	0	0	0
6 Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам	12374.2	4912.3	4782.84	4782.84	129.46	4897.3	15	4772.34	4772.34	15	15		15	15			
7 Барилга хот байгуулалтын яам																	
Дүн	51,166.17	26,593.30	23,762.59	2,830.72	23,753.03	15.00	3,314.17	16,870.04	2,397.55	2,495.49	2,004.26	3,390.08	4,949.80	64.82	1,123.86	0.00	0.00

4,787.34

1 Гадаад хөрөнгийн сайдын багц	2618.7	2618.7	2618.7	0	2588.7	30.0	426.1	2192.6	426.1	2192.6							
2 Эрүүл мэндийн сайдын багц	13444.8	11880.9	11213.8	667.1	9964.3	1249.5	8781.4	294.8	605.9	1531.9							
3 Үйлдвэр, худалдааны сайдын багц	373.3	373.3	360.7	12.6	184.7	176.0	177.8	18.9	18.0								
4 Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын багц	5903.8	5667.0	5900.3	-233.3	5167.1	733.2	4913.1	652.0	335.2								
5 Сангийн сайдын багц	6085.9	5062.5	4362.4	700.1	3765.6	597.0	3397.8	105.5	636.4	223.0							
6 Шүүхийн ерөнхий зөвлөл	250.7	158.6	158.6	0	158.6	158.6	113.6	45.0									
7 Улсын дээд шүүх	92.1	93.3	92.1	1.2	65.1	27.0	65.1	27.0									
8 Санхүүгийн зохицуулах хороо	70	70	70.9	-0.9	70.9	70.9	40.2	30.7									
9 Ерөнхий прокурорын газар	107.1	107.1	107.1	0	80.0	27.1	80.0	27.1									
10 Зам тээвэр, аялал жуулчлалын сайд	63793.8	5175.7	3106.5	2068.2	3106.5	102.8	2891.2	112.5	102.8								
Дүн	92740.2	31207.1	27991.1	3216	24922	3069.3	20306.4	938.9	4562.5	2183.8							

1 Шаар сайд	25.00	25.00	27.00	(2.00)		27.00	12.00	15.00									
2 ХХААЯ	14,020.05	14,020.05	12,689.35	1,330.70	12,689.35		11,134.75	1,530.70	23.90								
3 ОЕБГазар	1,419.20	1,217.70	1,216.60	1.10	1,163.90	52.70	1,163.90	52.70								10114	
4 БХЯ	3,772.00	3,771.97	3,646.97	125.00	3,301.40	463.50	17.10	2,842.50	17.10	912.40							
5 Ерөнхий сайд	18145	18145	18145	-	18145	18145	3,858.30	18145									
6 ХЗДХЯ	5,751.90	5,751.90	5,751.70	(0.20)	5,751.90		328.10	243.00	1,322.00					278.30	156.90	546.50	
Нийт дүн	25,169.60	24,968.07	23,513.07	1,454.60	22,906.55	453.50	278.25	18,999.45	1,858.80	296.00	2,483.55	2183.8	278.30	156.90	647.64	546.50	-

Нийт дүн	169,075.97	82,768.47	75,266.76	7,501.32	71,581.58	468.50	6,661.72	56,175.89	5,195.25	7,353.99	6,671.61	3,390.08	5,228.10	221.72	1,771.50	-	-
-----------------	-------------------	------------------	------------------	-----------------	------------------	---------------	-----------------	------------------	-----------------	-----------------	-----------------	-----------------	-----------------	---------------	-----------------	----------	----------